



2022 ОНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ЧИГЛЭЛ ЦУВРАЛ

“Энэхүү бүтээлийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд МУИС-ийн Хууль зүйн сургууль болон Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн багш, судлаач оюутнуудын баг хийж гүйцэтгэв. Бүтээлд илэрхийлэгдсэн агуулга, дүгнэлт, санал нь судлаачдын үзэл санаа бөгөөд АНУ-ын засгийн газар эсхүл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.”

Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 24 улс төрийн намын төлөөлөл “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг” гаргаж дараах 8 чиглэл бүхий асуудлаар 2022 оны 06 сарын 09-ны өдөр “Тунхаг бичиг”-т нэгдэн гарын үсэг зурсан билээ. Тус “Тунхаг бичиг”-т тусгагдсан 8 саналыг Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтын хамтаар танилцуулж байна.

*Санал тус бүрийн агуулгатай уялдуулан нэмэлт, өөрчлөлт орох боломжтой заалтуудыг таамаглан дэвшүүлэв. Энэ нь албан бус мэдээ болно.

№	Тунхаг бичигт тусгасан ҮХНӨ оруулах чиглэл	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хамрах хүрээ	1992 оны Үндсэн хууль дахь холбогдох зохицуулалт ¹
	Хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах (хүний	Нэг. Хүний эрхийг хуулиар бүрэн хамгаалах - Хүний нэр төр халдашгүй байна. Төрийн бүх байгууллага иргэнийхээ нэр төрийг хүндэтгэн хамгаалах үүрэг хүлээх.	64.1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудын ишлэв. [МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ](#)

1	эрхийг баталгаажуулах, хүний үндсэн эрхийг Үндсэн хуулийн цэцээр хамгаалах тогтолцоог бэхжүүлэх);	<ul style="list-style-type: none"> - Хүний амьд явах эрхийн баталгааг хангаж, цаазын ялыг бүрэн халах - Иргэний улс төрийн эрхэд тавьсан хязгаарлалтыг арилгаж, тэгш боломж олгох - Иргэн үндсэн эрхээ Үндсэн хуулийн цэцээр хамгаалуулах - үндсэн хуулийн цэц нь улс төрөөс хараат бус, Үндсэн хуулийн шүүх байх. 	<p>66.1. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.</p> <p>2. Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна: 1/хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх; 2/ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх; 3/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх; 4/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.</p>
2	Иргэдийн эвлэлдэх нэгдэх эрхийг хязгаарласан заалтыг засах		19 ¹ .2. Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.
3	Хурдтай өөрчлөгдөж буй олон улсын шинэ нөхцөл байдалд Монгол Улын тусгаар тогтнол, эв нэгдэл, үндэсний аюулгүй байдлын баталгаа болсон	<p>Хоёр: Ард түмнийг төлөөлөх парламентын чадавх, хариуцлагыг нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Сонгогчдын санал гээгддэг байдлыг арилгаж, сонгуулийн холимог систем бүхий хариуцлагатай, сонгодог 	21.1. Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна.

	парламентын засаглалыг бэхжүүлэх	парламентын тогтолцоог төлөвшүүлэх замаар олон намын оролцоотой зөвшилцлийн ардчилалд шилжих.	
4	Ард түмнээ бүрэн төлөөлөх парламентын чадавыг нэмэгдүүлж, иргэдийн санал жигд тусгалаа олдог олон улсын жишигт нийцүүлэх	<ul style="list-style-type: none"> - Хурдтай өөрчлөгдөж буй олон улсын шинэ нөхцөл байдалд Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгаа болсон парламентын засаглалын тогтолцоог бэхжүүлэх. - Ард түмнийг төлөөлөх парламентын чадавхыг сайжруулах зорилгоор сонгогчдыг төлөөлөх мандатын тоог нэмж, Улсын Их Хурлын нэг гишүүний нөлөөллийн эрх мэдлийг багасгах. 	21.4. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.
5	Популист улс төрөөс татгалзаж, хөгжлийн хөтөлбөрөөр өрсөлддөг үндэсний хэмжээний бодлогын намуудыг төлөвшүүлэх	<ul style="list-style-type: none"> - Хууль тогтоох болон Гүйцэтгэх эрх мэдлийн хяналт, тэнцэл, уялдаа холбоог зохистой болгох. - Төрийн институтүүдийн эрх, үүргийг тодорхой болгон, тогтолцооны хоёрдмол байдлыг арилгаж, олон улсын жишигт нийцсэн сонгодог парламентын засаглалыг төгөлдөржүүлэх. 	19 ¹ . 1. Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана. 191.3. Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.
6	Хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн зохист уялдаа, хяналт тэнцлийг хангах		39.1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. <i>\Тус заалтанд 2022.08.25-ний өдөр өөрчлөлт орсон\</i>
7	Хөгжлийн нэг төвтэй улсаас олон төвтэй улс болох зорилгоор нийслэлийн эрх зүйн байдлыг оновчтой болгож бусад хотын хөгжлийг дэмжих	<p>Гурав: Хот, хөдөөгийн хөгжлийг дэмжих, нутгийн удирдлагын тогтолцоог сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> - Төвлөрлийг сааруулах, хот, хөдөөгийн ялгааг багасгах, хөгжлийн нэг төвтэй улсаас олон төвтэй улс болох зорилгоор нийслэлийн эрх зүйн байдлыг оновчтой болгож бусад хотын хөгжлийг дэмжих. 	13. 1.Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн. 13.2.Монгол Улсын нийслэлийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. 57.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

		- Нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэхийг Үндсэн хуулийн цэц хянах.	Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.
8	Төрийн сүлдийг төрт ёс, түүхэн уламжлалд суурилж шинэчлэх	Дөрөв: Монгол Улсын төрийн сүлдийг шинэчлэх - Төрийн сүлдийг төрт ёс, түүхэн уламжлалд суурилж шинэчлэх.	12.1.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн. 12.2.Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ. 12.3.Төрийн сүлд нь ариун цагаан өнгийн бадам цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугариг хөх дэвсгэртэй байна. Сүлдний төв хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдний хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн уулан хээ, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна.

Хүснэгт 1: Тунхаг бичигт тусгагдсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэл болон Үндсэн хуулийн холбогдох заалт

Эх сурвалж - 1: Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс:
[Үндсэн хуульд өөрчлөлт оруулахыг улс төрийн намын төлөөллүүд дэмжиж, тунхаг бичигт гарын үсэг зурлаа](#)

Эх сурвалж - 2: Монгол Ардын Нам
[Монгол Ардын Нам - Тунхаг бичиг](#)

Эх сурвалж - 3: УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн
[Линк](#)

Эх сурвалж - 4: Тунхаг бичгийн зургийн эх сурвалж
[Линк](#)

Бэлтгэсэн:
Судалгааны баг
2022 оны 9 дугаар сарын 19